



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2017 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/48

Улаанбаатар хот

**Нийтийн тээврийн үйлчилгээг зуны
хуваарьт шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Тээврийн газрын “Дүрэм”-ийн 2.5.3, 3.1.19 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Оюутан сурагчдын амралт эхэлж, иргэдийн зорчих урсгал багассантай уялдуулан нийтийн тээврийн үйлчилгээнд өдөр тутам ажиллах тээврийн хэрэгслийн тоог 10 хувиар бууруулж зуны цагийн хуваарьт шилжүүлж 2017 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Чиглэлүүдийн үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн тоог тогтоож, цагийн хуваарийг боловсруулж нэгдсэн даалгаварт тусгахыг Тээврийн төлөвлөлт, технологийн хэлтэс /Д.Галбадрах/, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /Ц.Мөнхбат/, чиглэлүүдийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж, шуурхай зохицуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс /Э.Баярт/, үйлчилгээг батлагдсан замналын дагуу явуулах, ажиллах цагийн хуваарийн мөрдөлтөд хяналт тавьж ажиллахыг Тээврийн хяналтын хэлтэс /Ц.Мягмар/-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Булгаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОТГОНБААТАР